

Нэг суралцагчийг Лук 18:18–23-ыг уншаад, үйлчлэх урилгад Бригам Янгийн үзүүлсэн хариу үйлдэл энэ цэдэг дээрх Аврагчтай харилцаж байсан хүнийхээс хэр ялгаатай байсныг олж мэдэхэд урь.

- Бригам Янгтай адил золиос гаргахыг хүсдэг байхад бидэнд тусалж болох Их Эзэний талаар та юу мэдэх вэ?
- Номлолд үйлчлэхээс гадна Их Эзэний Өөрт нь үйлчлэхийн тулд биднээс золиослоосой гэж хүсэж болох өөр ямар ямар арга зам байдаг вэ?

Их Эзэнд үйлчлэхийн тулд золиос гаргах хүсэлтэй байх нь танд ямар санагдаж байгааг хуваалц.

3-р ярилцлага БРИГАМЫН ИХ БРИТАНИ ДАХЬ НОМЛОЛ

Дараахтай төстэй асуулт тавьж эхлүүлээрэй.

- Их Эзэний тусламж номлогчид хэрэг болох зарим шалтгаан юу вэ?

Дараахыг унш эсвэл нэгтгэн дүгнэ.

Дахин гэрлэж, өөр таван номлолд үйлчилснийхээ дараа Бригам бусад төлөөлөгчийн хамт Их Британид номлолд үйлчлэхээр дуудагджээ.

Бригам номлолоо ийн дүрсэлсэн.



Бид хүний нутагт харийн газрын мөнгөгүй хүмүүс шиг очсон боловч Бурханы нигүүлслийн ачаар бид олон найзтай болж, Их Британий хаант улсын ихэнх томоохон хот, тосгонд сүмээ байгуулан, 7–8 мянган хүнд баптисм хүртээж, 5000 Мормоны Номыг хэвлэсэн, . . . мөн олон мянган хүний зүрх сэтгэлд мөнхийн үнэний үрийг тарьсан. . . ба эдгээр бүх зүйлийн төлөө би Бурханы мутарт талархаж байна. (*Teachings of Presidents of the Church: Brigham Young* [1997], 6)

Нэг суралцагчийг Алма 26:12–13 дээрх Аммоны үгийг уншихад урь. Тэгээд дараах асуултыг тавь.

- Бригам Янгийн хэлсэн зүйлийг Аммоныхтай харьцуулахад ямар байна вэ?
- Их Эзэнд үйлчлэхийг хичээхдээ Түүнд тулгуурлах нь яагаад чухал гэж та бодож байна вэ?
- Та Их Эзэнд үйлчилж байхдаа хэрхэн Түүнд тулгуурлахыг хичээсэн бэ?

Их Эзэнд үйлчлэхдээ Түүнд тулгуурлах тухай бодол, мэдрэмжээ хуваалц.